ГАРЧИГ

ОРШИЛ ........ 2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХАРЪЯАЛАЛ ........ 4
Хүснэгт. 1 Товч тоон мэдээлэл ........ 5
Хүснэгт. 2 Газрын солбицол ........ 8
Хүснэгт. 3 Барилгын хэмжээ ........ 8
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ ........ 9
Хүснэгт 4. Сөрөг нөлөөлөл ........ 9
Хүснэгт 5. Нөлөөлөл тодорхойлолт ........ 10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 11
Хүснэгт 6. БОМТ-ний зардлын задаргаа ........ 11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 12
4.1 Агаарын чанар ........ 12
4.2 Усны чанар ........ 14
4.3 Ургамлан нөмрөг ........ 15
4.4 Хөрсөн бүрхэвч ........ 15
4.5 Амьтны аймаг ........ 16
4.6 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ ........ 16
6. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 18
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 19
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 19
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 19
10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 20
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 21
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН МЕНЕЖМЕНТ ........ 23
**12.1** БОМ-н төлөвлөгөөнд байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэхэд хэлтэс албадын үүрэг оролцоо ........ 24
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ) ........ 25
14. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад талуудад хэлэлцүүлэх хуваарь ........ 28
15. ХАВСРАЛТУУД ........ 29

## ОРШИЛ

Мөнхийн баян гал” ХХК-ний Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар боловсруулалт явуулахад чиглэх, мөн учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дараахь чиглэлүүдээр хийж хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:

Хуулийн ерөнхий нийцэл
Усны нөөц ашиглалт, усны чанар, бохирдол
Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлт
Ургамлан нөмрөг, биологийн олон янз байдал ба биологийн нөхөнсэргээлт
Агаарын чанар, физик нөлөөлөл
Хог хаягдал, химийн бодисын менежментийн аудит
Технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа тус тус хамаарна.

Мөн түүнчлэн байгууллагын хүрээнд баримтладаг байгаь орчны уриа зарчим бол
Бүтээн байгуулалтад байгалийн баялгыг зүй зохистой ашиглана.
Ус агаар биологийн олон янзын байдал хог хаягдал, газар зохион байгуулалт зэрэг чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэн Монгол улсын байгаль орчны тухай хуулийг хэрэгжүүлэж ажиллах.
БАЙГАЛЬ ОРЧНОО ХАЙРЛАХ БИДНИЙ ҮҮРЭГ
Бид явуулж буй үйл ажиллагаанаасаа байгаль орчинд учруулах нөлөөллийг бууруулах,арилгах цаашилбал байгаль орчны өндөр стандартыг тогтоож, орон нутгийн ард иргэдийн санал зөвөлгөөг үйл ажиллагаандаа тусгаж ажиллаж байна.
БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ
Бидний үйлдвэрлэлийн онцлог давуу тал хуурай аргын буюу байгаль орчинд ээлтэй шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн дэвшилтэт ололтыг бүрэн нэвтрүүлсэн. Үйлдвэрийн цех дамжлагууд бүрэн автомат.Тоосжилтын хэмжээ болон хүлэмжийн хийн ялгаруулалт маш бага, ус эрчим хүч, түлшний хэмнэлттэй. Байгаль орчин сөрөг нөлөө бага эко үйлдвэр юм.
арилгах үүрэг амлалт хүлээсэн. Бид цаашид ч байгаль орчны өндөр стандартыг тогтоож, байгаль орчны мэргэжилтнүүд болон үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн ард иргэдийн зөвлөгөөг хэрэгжүүлэх болно.
Сэргийлэх - “Сэрэмжлэх арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдалд бодитнөлөөлөл үүсэхээс өмнө буюу тоосжилт болон дуу чимээ цацраг идэвхит бодис алдагдах нөхцөл үүсэхээс сэрэмжлэх
Багасгах – “Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн үйлдвэрлэлийн болонболовсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн олон янз байдалд учирч болох хохирлыг багасгаж болох арга хэмжээнүүдийн тусгасан байна.
Нөхөн сэргээх – “Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар нутгуудад тогтвортой газрын төрх, тогтцыг бий болгох бэлтгэл ажлууд, ургамалжуулж амьдрах орчныг дахин сэргээх ажил. Амьдрахорчныг сэргээх арга хэмжээ нь нөхөн сэргээлтээс бага зэрэг ялгаатай байна. Энэ нь тухайн амьдрах орчныг эвдрэлд өртөхөөс өмнөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.
Байгаль хамгаалах төлөвлөгөө, хяналт шинжилгээний гол зорилт нь БОНБНҮ-тэй уялдуулан үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад чиглэгдэж, дараах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| ***Төслийн нэр:*** | ***“Цементийн үйлдвэр”*** |
| ***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:*** | “Мөнхийн баян гал” ХХК<br>Регистрийн дугаар: 5118115 |
| ***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*** | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо Махатма ганди гудамж GALAXY TOWER-8005 тоот, Утас: 95380000, 88088847 |
| ***Төслийн зорилго, ач холбогдол:*** | Монгол улсын стандартын шаардлага хангасан цемент үйлдвэрлэж, барилгын салбарт өсөн нэмэгдэж буй цементийн хэрэгцээний тодорхой хэсгийг хангах зорилготой. |
| ***Төслийн байршил:*** | “Мөнхийн баян гал” цементийн үйлдвэр нь Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт Улаанбаатар хотоос урагш 64 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 31 км, Сэргэлэн сумаас зүүн тийш 22 км, Налайхаас урагш 23 км-т Сэргэлэн сумын 1-р багийн нутагт, Төмөр замын 7 дугаар зөрлөгөөс урагш / хуучин орос цэргийн ангийн хойно / салаа төмөр замын далан дагуу цахилгаан дэд станц хүртлэх нутагт нийт 108 га талбайг хамарч оршино |




***Зураг.1 Тойм байршил зураг***

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХАРЪЯАЛАЛ

Үйлдвэрийн үйл ажиллагаа явагдаж буй талбайн хүрээгээр 107.93 га эдэлбэр газархамрагдаж байна. Эдэлбэрийн төв хэсэгт орших үндсэн барилга дотор үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагддаг ба технологийн цехүүд, түүхий эд болон бэлэн насосны станц, авто гараж, засвар механикийн хэсэг, цэвэрлэх байгууламж, лаборатори, уурын зуух, оффис, ажилдчын амрах байр, цайны газар, хүлэмж зэрэг хэд хэдэн жижиг барилгуудыг ашигладаг.



*Зураг.2 Байршил зураг*

***Товч мэдээлэл:***

| № | Үзүүлэлтүүд | Тодорхойлт |
|---|---|---|
| 1 | Аж ахуй нэгжийн нэр | “Мөнхийн баян гал” ХХК |
| 2 | Улсын бүртгэлийн дугаар | 9019024058 |
| 3 | Регистрийн дугаар | 5118115 |
| 4 | Төслийн нэр | Цемент боловсруулах үйлдвэр |
| 5 | Газар ашиглах гэрчилгээний дугаар | №0340838 |
| 6 | Газар ашиглах шийдвэрийн дугаар | Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн 47 тоот шийдвэр |
| 7 | Газрын хэмжээ | 108 га |
| 8 | Газар ашиглах зориулалт | Үйлдвэрлэл |
| 9 | Үйлдвэрлэх түүхий эд | Портланд цемент |
| 10 | Жилд үйлдвэрлэх хүчин чадал | 1 сая тонн |
| 11 | Газрын байршил | Төв аймаг Сэргэлэн сум 1 дүгээр баг |
| 12 | Үйл ажиллагаа эхэлсэн он | 2015 он |
| 13 | Одоогийн байдал | 2022 оны байдлаар Үйлдвэрийн шатаах зуухны хэсэгт эвдрэл гарсан тул үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогссон байна. |
| 14 | Түүхий эд | Шохойн чулуу, шар шороо, төмрийн баяжмал, байгалийн шохой, гөлтгөнө, цеолит, нүүрсний үнс |
| 15 | Ажиллах горим | 03 дүгээр сараас 11-р сар хүртэл |

*Хүснэгт. 1 Товч тоон мэдээлэл*

***Зорилго чиглэл:*** Монгол улсын болон, олон улсын шаардлага стандартыг хангасан цемент үйлдвэрлэж барилгын салбарт өсөн нэмэгдэж буй цементийн хэрэгцээний тодорхой хувийг хангажажиллах болон улс орны томоохон бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах зорилго тэмүүлэлтэй.

***Ач холбогдол:*** Дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн хуурай аргын технологоор байгаль орчиндсөрөг нөлөө багатай, дэвшилтэт технологоор баяжуулан үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх хүсэл зорилготой бөгөөд, тухайн ажлын хүрээнд байгаль орчны нарийвчласан үнэлгээ болон тухайн жилбүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулан хариуцлагатай байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг эрхэлж, орон нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангаж ажиллаж байна.

**Үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын түүхэн товчоо:** 2009 онд БНХАУ-ын улс төрийн хорооны байнгын гишүүн Монголд айлчлах үеэр Ерөнхий сайд нарын оролцоотойгоор Бүх Хятадын барилгын материал үйлдвэрлэлийн корпорацийн ТУЗ-ийн дарга болон Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд нарын цементийн үйлдвэрийн төслийн санамж бичигт гарын үсэг зурснаар энэхүү цементийн үйлдвэр барих үндэс болсон.

Манай компани нь 2007 онд цемент үйлдвэрлэж цементийн эрэлтийг бууруулах зорилгоор, нийт, 850 сая юаны хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Бид Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг,
7-р зөрлөгт өдөрт хуурай аргаар 2500 тонн чулуунцар боловсруулах дамжлага бүхий жилд нэг сая тонн цемент тээрэмдэж үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтанд оруулаад байна.

Төслийг дэвшилтэд технологи, байгаль орчинд ээлтэй, чанарын өндөр баталгаатай үйлдвэрлэх технологийг мөрдөж, DCS хяналтын систем нэвтрүүлэн , сүүлийн үеийн тоос шүүх дэвшилтэттехнологи ашиглаж, үйлдвэрийн энерги зарцуулалтыг хамгийн доод хэмжээнд хүрнэ.

Төсөл нь хуурай аргаар цемент үйлдвэрлэх технологи ашиглаж Улаанбаатар дахь цахилгаанстанцын хаягдал үнс, төмрийн үйлдвэрийн хаягдал зэрэг материалыг хольц болгон цемент үйлдвэрлэнэ.

**Үйлдвэр орчмын уур амьсгал**

Төв аймгийн Сэргэлэн сум орчмын уур амьсгалын төлөв байдлын үзүүлэлтүүдийг статистикаргаар боловсруулан үзэхэд агаарын температур хүйтний улиралд-23.5$^0$С15.8$^0$С, дулааны
улиралд +13.2$^0$С...+16.2$^0$С (1965-2013) бол хөрсний гадаргын температур өвөл -25.0$^0$С16.7$^0$С, зун +18.7$^0$С ... +23.7$^0$С (2000-2013). 1990 оноос хойш илэрхий дулаарсан байна. Сүүлийн 14 жилийн хугацаанд тогтвортой дулаарч эхлэх өдөр 1-2 өдрөөр эрт, хүйтэрч эхлэх өдөр илүү эрчимтэйгээр 4-5 өдрөөр хойшилсон байна. Тиймээс дулаан өдөр 5-6 өдрөөр уртассан ба дунджаар 179 өдөр байдаг байна.

Хур тунадасны жилийн хэлбэлзэл ихтэй хэдий ч ялимгүй бууралтын хандлага илэрсэн бөгөөд хур тунадас ихтэй жилдээ 280-460мм, багатай жилдээ 177-270 мм орсон. Салхины сарын дундаж хурд 1.4-3.6м/с боловч хамгийн их хурд 12.8-19р.9м/с хүрдэг байна. Салхины хурд 10м/с-ээс их өдрийн тоо жилдээ 5-15. Салхины зонхилох зүг баруун, баруун хойд болон хойноос (67.4%) салхилдаг. Хаврын эхэн сараас зуны сар гарах хүртэл салхи шуурга ихтэй байдаг нь газрын гадаргын хөрснийэвдрэл, чийгийн алдагдлыг ихэсгэдэг.

Харьцангуй чийг өвөл, зун харьцангуй их 60-70% бол хавар, намартаа бага 45-50% байна. Чийгтэй өдөр бага, 31 өдөр байхад хуурай өдөр 120 байна. Цасан бүрхүүл XII-II саруудад тогтвортой тогтдог ба мөн IV-V сард ажиглагддаг бөгөөд цас ихтэй жилдээ 140-160 хоног, бага жилдээ 85-92 өдөр цасан бүрхүүл тогтдог байна.

Явган болон шороон шуурга харьцангуй бага (жилдээ 10 орчим) ажиглагдах боловч сүүлийн жилүүдэд илэрхий өсөх хандлага ажиглагдсан (2012 онд 25 удаа) байна. Цөлжилт илэрсэн байдлын зэрэглэлийн үнэлгээний үр дүнгээс харахад ихэнх нутгаар цөлжилтийн илрэл сул байгаа ч нутгийн баруун хойд хэсгээр “нэн хүчтэй” цөлжилт явагдаж байна. Ургамал бүрхүүлийн хувьд сийрэг, ургамлын био масс багатай (0.35-аас бага) байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн 2040 он хүртэлх ирээдүйн хандлагаас энэхүү Сэргэлэн сум орчмоор 1.4-2.48$^0$С дулаарч, хур тунадас 29 мм хүртэлх хэмжээгээр буурна гэсэн үр дүн гарч байна.

**Лаборатор:**

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс дээж сорьц авч физик механик шинж чанарыг тодорхойлох зориулалттай.

**Усан хангамж ариутгах татуурга:**

Өөрийн нутаг дэвсгэрт өрөмдөж гаргасан гүний худгийн эх үүсвэрээс усны хэрэгцээг хангадаг. Технологийн хэрэглээнээс бохир үүсэхгүй.

Ахуйн хэрэглээнээс үүсэх бохир усыг цэвэршүүлэн зайлуулах 2 хэсэг байгууламж байгуулж ашиглаж байгаа боловч байгаль цаг уурын нөхцөлд ажиллах боломжгүй байгаагаас үүдэн ашиглалтыг зогсоосон. Ахуйн бохир усыг үйлдвэрийн нутагт үүсгэсэн хүнхээл санд хуримтлуулдаг. Хаягдал усны санг хөрстэй шууд харьцах байдлаар байгуулсан.

**Технологи:**

Үндсэн технологи нь дараахь шат дамжлагуудыг дамжина. Үүнд:

- Түүхий эд /шохойн чулуу, шар шороо, нүүрсний үнс,төмрийн баяжмал, гөлтгөнө, цеолит, байгалийн шохой, түлшний нүүрс/- ийг тээвэрлэх, агуулах
- Түүхий эдийг бутлах, нунтаглах
- Түүхий эдийг бүтээгдэхүүний чанараас хамааруулан дозлох, янз бүрийнхарьцаагаар хольж нэгэн төрлийн болгох
- Эргэдэг зууханд түүхий эдийг кальцжуулах ба шатаах
- Клинкерийг хөргөх ба түүнийг гөлтгөнө, цеолит, байгалийн шохойтой холих
- Хольсны дараа цементийг нунтаглах,хадгалах, савлах, тээвэрлэх зэрэгхамаарна.

Эдэлбэр газарт байрших барилга обьектууд:

- Түүхий эд, материалын агуулах,
- Үйлдвэрийн барилга
- Удирдлагын өрөө, химийн бодисын агуулах, лабораториийн барилга
- Халаалтын зуухны барилга
- Оффис, ажилчдын амрах байр
- Ажилчдын цайны газар
- Засвар механикийн цех
- Бэлэн бүтээгдэхүүний агуулах гэх мэт обьектуудаас бүрдэнэ.

Үйлдвэрийн 2025 оны байдлаар байршлын солбицлуудыг доорхи хүснэгтэд үзүүлэв:

**Төслийн талбайн булангийн цэгүүдийн кординат**

| № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| 1 | E107° 18' 21.887” | N47° 32' 12.597” |
| 2 | E107° 18' 25.988” | N47° 32' 6.824” |
| 3 | E107° 18' 13.142” | N47° 32' 4.819” |
| 4 | E107° 18' 11.309” | N47° 32' 11.507” |
| 5 | E107° 17' 46.608” | N47° 32' 6.997” |
| 6 | E107° 17' 33.519” | N47° 32' 22.619” |
| 7 | E107° 17' 20.245” | N47° 32' 45.649” |
| 8 | E107° 17' 59.274” | N47° 32' 51.176” |
| 9 | E107° 18' 4.487” | N47° 32' 47.643” |
| 10 | E107° 18' 9.691” | N47° 32' 36.979” |
| 11 | E107° 18' 9.776” | N47° 32' 34.303” |
| 12 | E107° 18' 10.809” | N47° 32' 27.837” |
| 13 | E107° 18' 13.051” | N47° 32' 21.209” |

*Хүснэгт. 2 Газрын солбицол*

**Үйлдвэрийн газрын барилга байгууламжийн эзлэх талбайн гол үзүүлэлтүүд**

| Барилга байгууламжийн нэр | Хэмж. нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|
| Үйлдвэрийн эзлэх талбай | $м^2$ | 326 830 |
| Барилга байгууламжийн эзлэх талбай | $м^2$ | 34 200 |
| Түүхий эд хураах талбай | $м^2$ | 59 000 |
| Бэлэн бүтээгдэхүүн хураах талбай | $м^2$ | 21 000 |
| Үйлдвэр дотоод авто замын нийт урт | $м^2$ | 6 500 |
| Автозамын эзлэх талбай | $м^2$ | 28 960 |
| Ногоон байгууламж | $м^2$ | 32 000 |
| Хөдөлгөөн хийх хатуу хучилттай талбай | $м^2$ | 10 328 |

*Хүснэгт. 3 Барилгын хэмжээ*

**Бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** “Мөнхийн баян гал” ХХК нь ( ISO/IEC 17025:2017 ) ISO 9001:2015 зэрэг стандартуудыг хангасан OPC 42.5, PC 42.5, PC 52.5, CPC 32.5 портланд цемент, мөн сульфатын орчинд тэсвэртэй цемент үйлдвэрлэнэ. Цементийнхээ хэрэгцээнээс хамаарч 30 хүртлэх хувийг 50 кг-аар, 70 орчим хувийг задгай байдлаар зах зээлд нийлүүлнэ. Хэрэгцээ гарвал тн-оор шуудайтай үйлдвэрлэж болно.







*Зураг.3.Бүтээгдэхүүн*

## 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

**Богино хугацааны нөлөөлөл** Тээрэм бутлуур, шатаах зуух зэрэг хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах,хөрс бохирдох, мөн цементийн түүхий эд болох хөрс чулуулагууд ачих тээвэрлэх явцад тоос босох,дуу чимээ гарах зэрэг сөрөг нөлөөллүүд нь богион хугацааны нөлөөлөлд багтана.Түүнчлэн хур бороо багатай агаар хуурайшсан салхитай үед хөрсний овоолго зам тээврээс их хэмжээний органик бус тоос ялгарч ажиллагсдын эрүүл мэнд болоод хүрээлэн буй орчны хөрс ургамалд нөлөөлнө.

**Урт хугацааны нөлөөлөл** Түүхий эд олборлох, тээвэрлэх явцад байгалийн унаган төрх алдагдаж, хөрс ургамлын бүтцэд өөрчлөлт орж элэгдэл эвдрэлд оруулах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг дэс дараалалтай хийж хэвших нь хүрээлэн буй орчны цаашдын насжилтанд маш чухал юм.

Төслийн байршил,шийдэл,төлөвлөт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөлийг магадлан жагсаах

*Хүснэгт 4. Сөрөг нөлөөлөл*

| Байгаль орчны асуудлууд | Нөлөөллийн үр дагавар | | | |
|---|---|---|---|---|
| | Нөлөөгүй | Муу | Дунд | Сайн |
| **1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал** | | | | |
| Голын голдиролыг эвдэх,өөрчлөх,эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх | x | | | |
| Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох,хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах | x | | | |
| Ой модыг огтлох явдал гарах | x | | | |
| Түүх соёлын дурсгалт газрыг эвдэхэд хүрэх | x | | | |
| Усан хамгамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх | x | | | |
| Бүс нутгийн булаг, шанд хатах,ширгэх аюул гарах эсэх | x | | | |
| Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх | | | | x |
| **2. Цементийн үйлдвэрийн төслийн шийдэл, төлөвлөлттэй холбоотой байгаль орчны асуудал** | | | | |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс сэргийлэн хамгаалах болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудлыг төлөвлөлт | | | x | |
| Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагааны үед гарах шуугианыг тогтоосон хэмжээнээс | | | | x |
| Тусгай анхаарал тавих шаардлагатай цацраг идэвхит бодис, тоос, утаа гардаг эсэх | | | x | |
| **3.Төслийн үйл ажиллагааны үеийн байгаль орчны асуудал** | | | | |
| Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх | | | x | |
| Хөрсний элэгдлийг бууруулах,орчныг тохижуулах асуулдал төлөвлөгөөнд тусгагдсан байдал (нүхийг буцааж битүүлэх, хөрсжүүлэх ургамал тарих) | | x | | |
| Үйлдвэрийн технологийн болон ахуйн бохир усыг цэвэрлэлгүйгээр хаясанаас хөрсөнд нэвчин хөрсний болон гүний ус бохирдох, улмаар усны гольдиролд сөрөгөөр нөлөөлөх | | x | | |
| Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан ) | | x | | |
| Төслийн бусад асуудал (төслийн инженерийн болон санхүү,эдийн засгийн боломжийн талаарх асуудал) | | | x | |
| **4. Төслийн ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)** | | | | |
| Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад олдошгүй нөөц баялагыг зөвтгөх аргагүйгээр гарздах | x | | | |
| Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх (генофондод нөлөөлөх, ховор, нэн ховордсон амьтан ургамал устгах г.м ) | x | | | |

Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэгтгэл

*Хүснэгт 5. Нөлөөлөл тодорхойлолт*

| Нөлөөллийн төрөл | Эрчим | Үргэлжлэх хугацаа | Хамрах хүрээ | Магадлал | Нийт оноо | Онооны эзлэх хувь % | Нөлөөллийн зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт | | | | | | | |
| Гадаргын усны чанарын өөрчлөлт | - | - | - | - | - | - | - |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | 2 | 2 | 1 | 2 | 7 | 28 | Бага |
| Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол | 2 | 5 | 1 | 2 | 10 | 40 | Дунд |
| Геологийн тогтоцын өөрчлөлт | 2 | 2 | 1 | 1 | 6 | 24 | Бага |
| Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт | 2 | 5 | 1 | 1 | 9 | 36 | Дунд |
| Агаарынорчин /бохирдол/ | 6 | 5 | 1 | 2 | 14 | 56 | Дунд |
| Газар доорх усны нөөц | 8 | 5 | 2 | 4 | 19 | 76 | **Өндөр** |
| Дундаж | | | | | | **41.33** | Дунд |
| 2. Байгалийн нөөцийн ашиглалт | | | | | | | |
| Газрын гадаргын нөөцийн баялаг | 2 | 2 | 1 | 2 | 7 | 28 | Бага |
| Бэлчээр, тэжээлийн байдал | 2 | 2 | 1 | 1 | 6 | 24 | Бага |
| Эрдэс түүхий эдийн нөөц | 6 | 5 | 2 | 2 | 15 | 60 | Дунд |
| Дундаж | | | | | | **37,3** | Дунд |
| 3. Байгаль орчны өөрчлөлт | | | | | | | |
| Ундны усны чанар, хэмжээ | 2 | 5 | 1 | 2 | 10 | 40 | Дунд |
| Хөрсний бохирдол | 2 | 2 | 1 | 1 | 6 | 24 | Бага |
| Дуу чимээ, шуугианы нөлөөлөл | 2 | 1 | 1 | 1 | 5 | 20 | Бага |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | + | | | | | | + |
| Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх | + | | | | | | + |
| Дундаж | | | | | | **29,3** | **Бага** |
| 4. Байгалийн цогцолборт газар,түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх | 2 | 1 | 1 | 1 | 5 | 20 | Бага |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | 2 | 1 | 1 | 1 | 5 | 20 | Бага |
| Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх | - | - | - | - | - | - | - |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | - | - | - | - | - | - | - |
| Археологи, палентологийн олдворт нөлөөлөх | - | - | - | - | - | - | - |
| Дундаж | | | | | | **20** | **Бага** |
| 5. Бусад нөлөөлөл | | | | | | | |
| Автозамын тээвэрлэлтээс шалтгааланхөрс эвдрэх | 2 | 2 | 1 | 2 | 7 | 28 | Бага |
| Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих | 2 | 1 | 1 | 2 | 6 | 24 | Бага |
| Хүчтэйсалхи, түймэргазархөдлөл, аянга | 2 | 1 | 1 | 2 | 6 | 24 | Бага |
| Дундаж | | | | | | 25,3 | Бага |
| **Үрдүн**/ерөнхий дундаж/ | | | | | | **29,3** | **Бага** |

Тайлбар: **(-)**–нөлөөлөлгүй буюу байхгүй байгааг илэрхийлнэ.

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.
“Мөнхийн баян гал” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөлөлүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

“Мөнхийн баян гал” цемент боловсруулах үйлдвэр” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ, нөхөн сэргээлт ногоон байгууламжийн төлөвлөгөө, осол эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх зэргийг нарийвчилан тодорхойлж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, холбогдох зардлыг тусгав. Харин төслийн хүчин чадал, цар хүрээ, төслийн байршилаас хамааран дүйцүүлэн хамгаалах аргахэмжээ, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөг тусгаагүй болно.

Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт байрлах
“Мөнхийн баян гал” цемент боловсруулах үйлдвэр”-ийн 2025 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд нийт
*Хорин гурван сая гургаан зуун наян сая төгрөг* (23’680’000) төгрөг зардал төсөвлөж байна.
Бусад нэмэлт зардлуудыг үйлдвэрийн нэгдсэн үйл ажиллагааны зардал тусгаж өгсөн болно.

*Хүснэгт 6. БОМТ-ний зардлын задаргаа*

| Д/д | Бүрэлдэхүүн хэсэг | Төсөв /*мян.төг*/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 6.568.000 |
| 2 | Нөхөн сэргээлт ногоон байгууламжийн зардал | 9.494.000 |
| 3 | Химийн бодисын менежментийн төлөвлөгөө | 2.610.000 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1.050.000 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 2.358.000 |
| 6 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 750.000 |
| 7 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах хуваарь | 850.000 |
| 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв | | **23.680.000 төг** |

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөллийг бүрэлдэхүүн тус бүрээр авч үзэн тодорхойлоход нөлөөллийн эрчмын үнэлгээ бага буюу үр дагаврын нөлөөллийн үнэлгээ багатай төсөл юм. Иймд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд агаар орчин, хөрс, ургамлан бүрхэвчид нөлөөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөв. Хөрс, ургамлыг нөхөн сэргээх төлөвлөгөөг тохижилт ногоон байгууламжийн бүлэгт дэлгэрэнгүй тусгав. Төслийн нөлөөллийн бүсэд зэрлэг ан амьтан, гадаргын уст цэг байхгүй.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**“Мөнхийн баян гал” ХХК цементийн үйлдвэр сөрөг нөлөөллийн үйл ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэсэн болно.**

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тухайн үйлдвэрийн хашаанд ногоон байгууламжыг сайжруулах, нөхөн сэргээлт болон орчны усалгаа, тэр бум мод хөтөлбөр зэрэг тохижилтын ажлыг Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа 2022 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйлдвэрийн нэмэлт тодотголын тайлан болон 2025 онд гүйцэтгүүлэх Байгаль орчны аудитын тайланг иш болгон байгаль орчны талаарх ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгаа болно..

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн өртөг /сая. төг/ | Нийт зардал /сая. төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| *4. 1 Агаарын чанар* | | | | | | |
| Тоосжилт, дуу шуугиан үүсэж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Дуу чимээ, тоосжилттой ажлын байранд ажиллах ажиллагсдыг маск, иж бүрэн хувцас, чихний бөглөө, нүдний шил зэрэг хамгаалах хувцас хэрэгслээр хангах | Үйлдвэрийн ажилчдад | 2025 оны Үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөнд тусгана. | | 2025 он | MNS (ISO) 13994:2003 Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага . MNS 5010-2001 Тоос Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. |
| | Бутлах, шигших, нунтаглах, холих,ачих буулгах бүх цехүүдийн агааржуулах хоолой бүрт тоос баригч уутан фильтрүүдийн ашиглалт арчилгааг хийх шинэчлэх | Үйлдвэрийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгав. | | 2025 оны туршид | MNS 4930 : 2000 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Агаарын чанарын хяналт шинжилгээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх | Агаарын температур, чийглэгАгаарын урсгалын хурд | Түүхий эд, материалын эрсдэл бүхий хэсгүүд дээр | 810.000 төг | Жилд 2 удаа | Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий Шаардлага MNS 6999:2023 Testo1410-2, Testo 405-V1 |
| Орчны тоосжилт бууруулах | Үйлдвэрээс нэгдсэн засмал зам хүртлэх 8 км сайжруулсан шороон замыг засаж янзлан үе шаттай хатуу хучилттай засмал зам тавих ажлыг эхлүүлэх | 8км зам | Байгууллагын үйл ажиллагааны зардал буюу нэгдсэн төсөвт тусгаж өгөв. | 2025-2026 он | **БНбД 32.02.05** – Авто замын барилга, норм ба дүрэм **MNS 4598:2020** – Авто замын асфальт бетон хучилтын техникийн шаардлага **MNS 5342:2003** – Зам барилгын газар шорооны ажил |
| | Дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилтийг дарах зорилгоортоос дарах усалгаахийх (зуны улиралд), Зам талбайн усалгааг тодорхой хуваарийн дагуу хийж хэвших | Тээвэрлэлтийн зам дагуу 8км | Үйл ажиллагааны зардал тусгах | 2025 он | MNS4585:2016 Агаарын тухай хууль дагалдах стандартууд |

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн өртөг /сая. төг/ | Нийт зардал /сая. төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт,аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| *4.2 Усны чанар* | | | | | | |
| Гадаргын болон гүний ус бохирдох | Бохир ус цэвэрлэгээний 2 байгууламжийн үйл ажиллагааг хэвийн горимд бүрэн шилжүүлэх, | Гүний худагууд болон цэвэрлэх байгууламж | Байгууллагын дотоод үйл ажиллагааны зардалд тусгав. | | 2025 туршид | -Монгол улсын хаягдал усны MNS4943:2014 стандарт<br>- MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт.<br>- MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх- дээж авах, хадгалах, зөөвөрлөх<br>- MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга<br>MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга. |
| | Цэвэр ус болон хаягдал усны чанарын шинжилгээг улиралд 2-оос доошгүй удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Ашиглах буй бүх худагт | 237.000 төг | 948.000 төг | 2025он Улиралд 1 удаа | |
| Байгалийн усныөөц ашиглах, хамгаалах | Усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх | Бүх худгууд дээр | Ашигласан усны хэмжээг буюу тоолуурын дүнгээр тооцно.. | | 2025 жилийн турш | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль - 2012.05.17 |
| Үйлдвэрийн хэсэгт хяналтын цооногийн мэдээлэл нэгтгэх | Эрх бүхий мэргэжлийн байгууллагаар мониторингынцооногт нэгдсэн усны сүлжээний мэдээлэл нэгтгэх логгер төхөөрөмж суулгах | Үйлдвэрт | Үйл ажиллагааны зардал | | 2025 он | MNS 6088 : 2010 Худгийнцооногөрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавихтехникийншаардлага |

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн өртөг /сая. төг/ | Нийт зардал /сая. төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| *4.3 Ургамлан нөмрөг* | | | | | | |
| Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх | Ургамлын мониторинг судалгааг жилд 1-2 удаа явуулж, үр дагаврыг тогтмол хянах | Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав. | | 2025 он Жилд 1-2 удаа | - Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага.MNS 5546: 2005 Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална. |
| Ашиглалтын талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх | Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах | Үйлдвэрийн талбайд | Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав. | | Жил бүр | - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 |
| *4.4 Хөрсөн бүрхэвч* | | | | | | |
| Ахуйн гаралтай хог хаягдлыг цэвэрлэх, хог хаягдлын талбайд тээвэрлэх | Хог хаягдлын нэгдсэн цэгийг тохижуулах | Үйлдвэрийн одоо байгаа хогын цэгт | Үйл ажиллагааны зардал | | 2025 | Хог хаягдлын тухай хууль Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5344:2003 |
| Түүхий эдийн тээврийн 8 км зам нь орчны тоосжилт үүсгэх | Хуурайшилттай нөхцөлд усалгаа хийх, Зам засварын ажлыг гүйцэтгэх | Тээврийн зам, үйлдвэрийн тоосжил бүхий хэсэг | Дотоод санхүүжилтээр | | 2025 он | MNS,ISO 4227: 2002<br>MNS 0017-2-0-07:1979<br>MNS 0017-2-1-01 : 1978<br>MNS 4585:2007 |

<table>
<tr><td colspan="6">4.5 Амьтны аймаг</td></tr>
<tr><td>Үйлдвэрийн болон орчны талбай дахь амьтны аймаг нөлөөлөлд өртөх</td><td>Амьтны мониторинг судалгааг БО-ны аудитын дагуу мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх</td><td>Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд</td><td>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгах.</td><td>2025 он</td><td>Амьтан судлаачдын зөвлөмж, тусгай боловсруулсан арга зүй</td></tr>
</table>

<table>
<tr><th>Гол ба болзошгүй сөрөг нөлөө</th><th>Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</th><th>Арга хэмжээний цар хүрээ</th><th>Нэгжий нөртөг /сая. төг/</th><th>Нийт зардал /сая. төг/</th><th>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</th><th>Баримтлах стандарт, аргачлал</th></tr>
<tr><td colspan="7">4.6 Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ</td></tr>
<tr><td rowspan="3">Хүний эрүүл мэнд</td><td>Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах</td><td>Үйлдвэрийн ажилчдад</td><td colspan="2" rowspan="3">Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төсөвт оруулсан</td><td>Жилд 1-2</td><td rowspan="3">- Хөдөлмөрийн тухай хууль<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br>- Хөдөлмөрийн аюулгүй<br>- ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000<br>- Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005</td></tr>
<tr><td>Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж хэрэгслийг авч, байрлуулах.</td><td>Үйлдвэрийн байр, удирдлага, ажилтнуудын байр</td><td>2025 он жилд 1 удаа</td></tr>
<tr><td>Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах</td><td>Бүх ажиллагсад</td><td>Сар бүр 1-2 удаа</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Жил бүр тухайн жилийн,байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах | | Үйл ажиллагааны Дотоод төлөвлөлтөөр | Жил бүр | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам |
| Орон нутагтай хамтран ажиллах | Хяналт шинжилгээний үр дүнгүүдийг орон нутгийн захиргаа, нутгийн оршин суугчдад.танилцуулж, тэдний саналыг авах | Орон нутаг хамтын ажиллагаан ы хүрээнд | | 11-12 сар | |
| Байгаль орчин нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл | Байгаль орчны аудит хийлгэх | Үйлдвэри йн хүрээнд | 4.000.000 | 2025 он | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл. |
| **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ /сая.төг/** | | | **Засмал зам тавих болон, Мод тариалалтын ажлын мөнгөн дүн багтаагүй болно.! 2025 оны зардал: 6.568.000 төг** | | |

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нэгжийн өртөг /сая. төг/ | Нийт зардал /сая. төг/ | Хэрэгжүүл эх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| Үйлдвэрийн газрын байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөн байгуулах | Мод тарих /хайлаас, буйлс, улиас/ | Эзэмшлийн газрын 10%-иас багагүй талбай буюу 10.8 га талбай* Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 2 га талбайд мод тарих 3-н жилийн гэрээ хийгдсэн | 1-2 га-д тарих модны тоо 3000 ш суулгац 15 га * суулгацын дундаж үнэ 6000 төгрөг Мэргэжлийн байгууллага тариалалт хийнэ. | Үйл ажиллагааны зардал тусгагдсан | 2025 он | Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шардлага MNS 5918:2008 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл. |
| Үйлдвэрийн гадна зам, талбайн тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт | Зам талбайн тогтмол усалгаа, хучилт болон арчилгаа хийх | Үйлдвэрийн тээврийн гол болон туслах замууд | 45.000 | 9.000.0 | Жилийн туршид | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, MNS 5917:2008 (Агаарын чанарын стандарт) |
| Эвдэрсэн овоолго, шорооноос хөрс, тоос задгайрч тархах | Илүүдэл шороог зайлуулж, талбайг тэгшлэх | Овоолгын бүх талбай, тэгшлэлт хийсэн хэсэг | | 494.0 | 2-3 улиралд | "Газрын нөхөн сэргээлтийн аргачлал" (БОНХЯ), MNS 5914:2008 (Хөрсний чанар) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ногоон байгууламж арчилгаа хангалтгүйгээс ургамал хорогдох | Улирлын арчилгаа усалгаа хийх | Таримал мод бут, зүлэгжүүлсэн хэсгүүд | Гэрээт байгууллагын гэрээний дүнгээр | 1,3-р улиралд | Ногоон байгууламжийн стандарт MNS 6424:2013 |
| **НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН:** | | | **2025 оны зардал: 9.494.000 төг** | | |

## 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус үйлдвэрлэлээс орон нутгийн иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй бөгөөд байгаль цаг уур гамшиг ослын үед болон ихэвчлэн цас зудтай жилүүдэд  техник хэрэгсэл, хүн хүчээр туслах арга хэмжээ тогтмол авч ажиллдаг билээ.

## 8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийг хэрэгжүүлэх явцад биологийн олон янз байдалд эргэн нөхөн сэргэхээргүй сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй учраас биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж байгаль орчны нарийвчласан үнэлгээнд тусгаж өгсөн байна.

## 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

***А. Архелогийн судалгаа.*** Цементийн үйлдвэрийн орчим нь улсын чанартай авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам зэрэгт холбогдсон дэд бүтэц сайтар хөгжсөн бүс нутаг бөгөөд эртнээс эхлэн хүн тасралтгүй орших амьдарч байсан нутаг учир эртний түүх, архелогийн хайгуул судалгааны ажил хийгдээгүй учир Монгол улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалттайтүүх, архелогийн томоохон дурсгал бүртгэгдээгүй байна. Иймд түүхийн олон үеийн дурсгал байх магадлалтай хэдий ч уг газар нь намагтай, цэвдэг бүхий бамбалзуур хөрстэй байгаа нь дурсгал байх магадлалыг багасгаж байна. Судалгааны үр дүнд ямар нэгэн түүх археологийн дурсгал илрээгүй болно.

***Б. Палентологийн судалгаа.*** Төсөл хэрэгжих талбайд явуулсан палеонтологийн хайгуул, тандан судалгааны үр дүнд палеонтологийнолдвор эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илрээгүйболно. Гэсэн хэдий ч энэ талбайд тархсан девоны настай Горхи формацын улаан хасын үеүд нь микро амьтны үлдэгдэл радиоляр элбэгтэй бөгөөд түүнд силур-девоны цаг үеийн радиолярын 4 цогцолборыг ялгаж, хурдсын насыг нарийвчлан тогтоож байсан стратиграфийн ач холбогдолтой зүсэлтүүдтэй дүүрэгт тус цементийн үйлдвэрийн талбай хамаарагддаг тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Бидний судалгаагаар одоогоор цементийн үйлдвэр нь доод девоны Сэргэлэн формацын ногоон занарын зузаалаг дээр байрлаж байгаа нь тогтоогдсон тул палеонтлогийн талаас нөлөөлөх зүйлгүй юм.

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

## 10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэрэгжүүлэх хугацаа | Нийт зардал /мянга, төгрөг/ | Хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Химийн бодистой харьцах үеийн өдөр тутмын зааварчилгаа , Давтан зааварчилгаа | Лабораторт ажиллаж буй бүх ажилчид | 2025 оны турш тогтмол | Үйлдвэрийн урсгал зардалд тусгасан | БОХАБЭА-н хэлтэс мэргэжлийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ | Танхимийн болон ажлын байран дээрх зааварчилгаа, БОХАБЭА-н дарга хяналт тавина. | “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль |
| 2 | Химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэхарга хэмжээ авах, болзошгүй аюулын үед аврах баг бэлтгэх | Үйлдвэрийн бүх ажилчид | 2025 оны улирал тутам | Үйлдвэрийн урсгал зардалд тусгасан | Үйлдвэрийн захиргаа, БОХАБЭА-н хэлтэс | Химийн хорт бодистой агуулахын аюулгүй байдал хамгаалалтыг сайжруулах, гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах | “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль “Гамшигаас хамгаалахтухай хууль” |
| 3 | Химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны сургалт | Лабораторын химийн бодистой ажилладагажилчид | 2025 оны 02-р улиралд | 210.000 | БОХАБЭА-н хэлтэс, | Химийн бодистой ажилладаг ажилчид хор аюулын мэдлэгтэй болох | Химийн хорт болон аюултай бодисынтухай хууль |
